



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

Нутгийн удирдлагын ордон 201 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 70533620, Факс: (976) 70533604
Цахим шуудан: info@omnogovi.gov.mn
Цахим хуудас: www.omnogovi.gov.mn

2025.06.12 № 01/2259

танай _____-ны № _____-т

Хамтран ажиллах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 03/09 дүгээр тогтоолоор төр, хувийн хэвшлийн түншлэл, хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх дэд бүтэц, бүтээн байгуулалтын төслүүдийг батлуулан, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны "Өсөлттэй Өмнөговь" хөтөлбөрт тусгаж, 2025 оноос хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Уг ажлын хүрээнд 2024 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 2025/10 дугаартай хамтран ажиллах санамж бичгийн дагуу хамтран хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар хүргүүлж байна.

Иймд энэхүү төсөл, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх, техникийн болон мэргэжлийн дэмжлэг үзүүлэх зорилгоор танай байгууллагаас зөвлөх үйлчилгээний баг томилон хамтран ажиллахыг хүсэж байна.

Хавсралт хуудастай..

ЗАСАГ ДАРГА



Н.ЭНХБАТ

4625051118

Аймгийн Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын
12-ны өдрийн 07/234 дугаар албан бичгийн хавсралт



**ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ХҮРЭЭНД
ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН ЖАГСААЛТ**

1. Гурвансайхан нисэх онгоцны буудлыг олон улсын длыг олон улсын 4D зэрэглэлийн онгоцны буудал болгох;
2. Даланзадгад сумыг Монгол Улсын хэвтээ тэнхлэгийн автозамтай холбох;
3. Ханхонгор сумын “Шар тээг”-н уулзвар дээр тээвэрчдийн үйлчилгээний логистик төв байгуулах;
4. Өмнөговь аймгийн Сэврэй сумын нутагт баруун сумдын авто замын дагуу тээвэрчдийн үйлчилгээний төвийн зогсоол
5. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй нийгмийн дэд бүтцийн бүтээн байгуулалт;
6. Бүс нутгийн аялал, хил орчмын аялал жуулчлалын дэд бүтцийн байгуулалт;